

СУРГУУЛИЙН ЗАХИРГААНААС 2021 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН


2021.06.22

Аргатай

Төлөвлөсөн ажлын хүрээнд: Суурь боловсролыг 9 сурагч төгсөж боловсролын баримт бичгээ гардан авсан.



Сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд хийсэн ажлын зорилтын хэрэгжилтийн тайлангаа бүтцийн дагуу бичиж онлайнаар хамгааллаа.



Цөлжилтийн эсрэг хамтдаа 🌳🌳🌳🌳 [#8түмэнмод](#) тарих хөдөлгөөнд манай сургуулийн хамт олон, тэдний гэр бүл, 5 болон 9 дүгээр ангийн төгсөгчид эцэг эхийн хамт 🌺 нэгдэж, Мөн төр нийгмийн нэрт зүтгэлтэн Дэмчигийн Моломжамцын мэндэлсний 100 жилийн ой, Боловсролын байгууллага үүсч хөгжсний 100 жилийн ойг тус тус тохиолдуулан сургуулийнхаа хашаанд агч, голт бор, бургас, гүйлс, улаан

сухай, улиас, хайлаас чацаргана зэрэг нийлсэн 117 мод тарих ажлыг зохион байгуулан ажиллаж сургуулийнхаа ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Мөн бүх цэцгийн мандлууддаа үрээ шигтгэн суулгаж өдөр бүр усалж байна.



Сургуулийн спорт заал дотуур байрны орчимд хуралдсан элснээс 41 машин элс ачиж асгалаа.



Байгууллагын багш ажилчдынхаа бяцхан хөөрхөн үрс, ээжүүддээ эх үрсийн баяраар сайхан дурсамжийг үлдээн Жүнь Юань ХХК –ын гарын бэлгийг түгээн үйл

ажиллагаагаар видео цомог бэлтгэх ажлыг байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан.

